

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн холбоо” төрийн бус байгууллагатай хамтран “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг төсвийн зохих зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Нарантуяа* Б.НАРАНТУЯА

420582

Ерөнхий захирлын 2017 оны 09 сарын 04 өдрийн
#157 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ” СЭДЭВТ СУРГАЛТЫН
ТӨСВИЙН ТӨСӨВ**

№	Аймгийн нэр	Сургалтын зардал
1	Архангай	3.609.070
2	Булган	3.415.200
3	Говь-Алтай	3.685.550
4	Говь-Сүмбэр	2.541.200
5	Дархан-Уул	2.540.670
6	Завхан	4.038.550
7	Баянхонгор	8.521.400
8	Орхон	2.645.650
Нийт		30,997,290

Хянасан:

Боловсруулсан:


О.Баярсайхан

Д.Гантуяа /Ахлах нягтлан бодогч/

О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/

Ерөнхий захирлын 2017 оны 09 сарын 04 өдрийн
1157 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Монгол улсын хэмжээнд 2015 оны байдлаар мэргэжлээс шалтгаалсан өвчний нийт 9759 тохиолдол бүртгэгдсэнээс 1% /38/ нь эрүүл мэндийн салбарт ажиллагсад байна. Мэргэжлийн хувь авч үзвэл хими туяа эмчилгээний эмч, сувилагч, рентгений эмч, техникч зэрэг ажлын байрууд зонхилж байна. Мөн химийн бодисоос үүсэлтэй арьс харшил, амьсгалын замын архаг хордлогод өртөх болон цус цусан бүтээгдэхүүнтэй харьцдаг “халдварт, төрөх эмэгтэйчүүд, тарианы тасаг , мэс заслын тасаг”-ийн ажилчдын 30% нь В,С вирусын халдвар авсан ба сүрьеэ, хамуу зэрэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарсан халдварт өртөх, хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах зэрэг эрсдлүүд тохиолдож байна.

Эрүүл мэндийн салбарт гарч буй үйлдвэрлэлийн осол улсын хэмжээнд гарч буй нийт үйлдвэрлэлийн ослын 8,4%-ийг эзлэн жилд дунджаар 30 гаруй хүн өртөж байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын сүүлийн 3 жилийн статистикаас харахад 2013онд 32, 2014 онд 33, 2015 онд 26 тохиолдол бүртгэгдсэн байна.

Иймээс эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнууд, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэдлэг, ойлголтыг сайжруулах шаардлагатай байна.

Сургалтын зорилго: Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмч мэргэжилтнүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай хууль, стандартуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг олгож чадавхижуулахад оршино.

Сургалтын үргэлжлэх хугацаа: 1 өдөр байна. Хичээлийн нэг цаг нь 40 минут /30 минут сэдвийн талаарх үндсэн ойлголт, 10 минут нь асуулт хариулт/ үргэлжилнэ.

Хамрах хүрээ: 8 аймгийн Эрүүл мэндийн газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, нэгдсэн эмнэлгийн ХАБЭА асуудал хариуцсан мэргэжилтэн, өрхийн эмнэлгийн эмч, сумын эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгийн дарга нар хамрагдана.

№	Аймгийн нэр	Оролцогчдын тоо		
		Аймгийн төвөөс	Сумаас	Нийт
1.	Архангай	12	18	30
2.	Булган	15	15	30
3.	Говь-Алтай	8	17	25
4.	Говь-Сүмбэр	18	2	20
5.	Дархан-Уул	19	1	20
6.	Завхан	7	23	30
7.	Баянхонгор	12	38	50
8.	Орхон	19	1	20
Нийт		140	115	255

Сургалт зохион байгуулах хугацаа:

Баянхонгор, Говь-Алтай аймагт 9 сард, Архангай, Булган, Завхан, Говьсүмбэр аймагт 10 сард, Дархан-Уул, Орхон аймагт 11 сард зохион байгуулна


“Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө

д/д	Сэдэв	Ноогдох цаг		
		Бүгд	Лекц	Семинар Дадлага
1	Хөдөлмөрийн хууль, ХАБЭА тухай хууль, бусад эрх зүйн баримтууд	2	2	1
2	Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн асуудал	1	1	
3	Цахилгааны аюулгүй ажиллагаа	1	1	
4	Химийн бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	0,5	0,5	
5	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	1	1	
6	Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	1	1	
7	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогын шалтгаан бууруулах арга зам, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг судлан бүртгэх дүрэм	0,5	0,5	
8	Эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйлийг ажилтанд төлөвшүүлэх	0,5	0,5	
9	Цацрагын үүсгүүртэй харьцах үеийн аюулгүй ажиллагаа	0,5	0,5	
Бүгд цаг		8	8	1


**"ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙ" СЭДЭВТ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

д/д	Хугацаа	Сэдэв
1	08.30-09:00	Бүртгэл
2	09:00-09:10	Сургалтын нээлт / Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, МХАБЭМХ-ны тэргүүн/
3	09:10-09:40	Хөдөлмөрийн хууль, ХАБЭА тухай хууль, бусад эрх зүйн баримтууд
4	09:40-10:10	Хөдөлмөрийн хууль, ХАБЭА тухай хууль, бусад эрх зүйн баримтууд /Сургагч багш/
5	10:10-10:20	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
6	10:20-11:50	Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн асуудал
	10:50-11:00	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
7	11:00-11:20	Завсарлагааны цай
8	11:20-12:00	Цахилгааны аюулгүй ажиллагаа
9	12:00-12:10	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
10	12:10-12:40	Химийн бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа
11	12:40-12:50	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
12	12:50-14:00	Үдийн хоол
13	14:00-14:30	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
14	14:30-14:40	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
15	14:40-15:10	Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
16	15:10-15:20	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
17	15:20-15:50	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогын шалтгаан бууруулах арга зам, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг судлан бүртгэх дүрэм
18	15:50-16:00	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
19	16:00-16:20	Завсарлагааны цай
20	16.20-16:40	Эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйлийг ажилтанд төлөвшүүлэх нь
21	16:40-17:00	Цацрагын үүсгүүртэй харьцах үеийн аюулгүй ажиллагаа
22	17:00-17:10	Цацрагын үүсгүүртэй харьцах үеийн аюулгүй ажиллагаа
23	17:10-17:20	Хаалтын ажиллагаа
24	17:20-17:30	Нэгдсэн зураг авахуулах үйл ажиллагаа

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА



Д.ОЧИРСҮМ

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2017 оны 08дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 17/4

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид “Захиалагч” гэх/ нөгөө талаас Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн холбоо ТББ /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1. Гэрээний зорилго: “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг удирдамж, хөтөлбөрийн дагуу заасан цаг хугацаанд чанартай зохион байгуулах, батлагдсан төсвийн дагуу бэлтгэл ажлыг хангах, суралцагчдыг чанартай хоол, цайгаар хангаж хариуцлагатай зохион байгуулна. Захиалагч, Гүйцэтгэгч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх, үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

2. Гэрээний зүйл: ЭМХТ-ийн захиалгаар дараах сургалтуудыг зохион байгуулна. Үүнд:

1. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Баянхонгор аймагт 09 сард зохион байгуулах
2. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Говь-Алтай аймагт 09 сард зохион байгуулах
3. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Говьсүмбэр аймагт 10 сард зохион байгуулах
4. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Булган аймагт 10 сард зохион байгуулах
5. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Архангай аймагт 10 сард зохион байгуулах
6. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Дундговь аймагт 10 сард зохион байгуулах
7. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Завхан аймагт 10 сард зохион байгуулах
8. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Орхон аймагт 11 сард зохион байгуулах
9. “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг Дархан-уул аймагт 11 сард зохион байгуулах

3. Гэрээний үнэ: Энэхүү гэрээний нийт төсөв нь 9 удаагийн сургалтын зардлын нийлбэр 30.939.790 төгрөг байна. Үүнд:

№	Аймгийн нэр	Бүгд /төг/
1.	Архангай	3.404.430
2.	Булган	3.324.560
3.	Говь-Алтай	3.723.910
4.	Говь-Сүмбэр	3.324.560
5.	Дундговь	3.277.290
6.	Дархан	3.259.360
7.	Завхан	3.723.910
8.	Баянхонгор	3.552.760
9.	Орхон	3.349.010
	Нийт	30,939,790

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

1. Захиалагч нь сургалтын явцтай танилцах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, сургалтын чанар, зохион байгуулалтанд хяналт тавих

2. Батлагдсан төсвийн дагуу сургалтын зардлыг гүйцэтгэгч талын нэхэмжлэлийг үндэслэн цаг хугацаанд нь шийдвэрлэж тасралтгүй байдлыг хангах. Хяналт тавих

3. Захиалагч нь ажлын захиалга өөрчлөх, хугацаа сунгах зэрэг тохиолдолд гэрээний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж баталгаажуулна. Нэмэлт өөрчлөлт орсон хэсгээс бусад үндсэн гэрээний нөхцөлүүд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ

4. Сургалтын зохион байгуулалттай холбоотой доголдолтой зүйл гарвал / Хоол хүнс чанарын шаардлага хангаагүй, гүйцэтгэгч талаас харилцааны зүй бус үйлдэл гарах / Захиалагч догодлыг арилгуулах, санал гомдлыг шийдвэрлүүлэх, гарсан зардлыг нөхөн төлүүлнэ

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

1. Гүйцэтгэгч нь захиалагчийн сургалтын удирдамж, хөтөлбөрийн дагуу онол практик хослуулан батлагдсан төсөвт багтаан сургалтын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд, алдаа дутагдал гаргалгүй зохион байгуулна.

2. Суралцагчдын мэдлэг чадварын түвшинг дээшлүүлэхээр шинэ мэдээ мэдээллээр хангах, сургалтын үр дүн гаргах

3. Захиалагчийн өгсөн сургалтын мэдээ, мэдээлэл, тоо баримтын нууцыг хадгалах өөр зориулалтаар ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно

4. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, стандартыг баримталж сургалтанд хамрагдаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудтай зөв боловсон харьцах

5. Гэрээнд заасан хугацаанд сургалт зохион байгуулагдаагүй эсвэл алдаа дутагдал гарвал гарсан тохиолдолд хугацаа хоцорсон хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн нийт дүнгийн 0.2 хувиар алданги хүлээнэ

6. Ажил гүйцэтгэгч нь гэрээний 1.2 заасан саруудад сургалтыг зохион байгуулна.

7. Батлагдсан төсвийн дагуу сургалтын хэрэглэгдэхүүн, амт чанартай хоол хүнсээр хангах

Дөрөв. Бусад

1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба бичгээр үйлдэнэ.

3. Гэрээний явцад үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба харилцан тохиролцох боломжгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭМАХА-НЫ ДАРГА



З.НАРАНБААТАР

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАТЗОРИГ

Ерөнхий захирлын 2017 оны 09 сарын 04 өдрийн
1/157 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Монгол улсын хэмжээнд 2015 оны байдлаар мэргэжлээс шалтгаалсан өвчний нийт 9759 тохиолдол бүртгэгдсэнээс 1% /38/ нь эрүүл мэндийн салбарт ажиллагсад байна. Мэргэжлийн хувь авч үзвэл хими туяа эмчилгээний эмч, сувилагч, рентгений эмч, техникч зэрэг ажлын байрууд зонхилж байна. Мөн химийн бодисоос үүсэлтэй арьс харшил, амьсгалын замын архаг хордлогод өртөх болон цус цусан бүтээгдэхүүнтэй харьцдаг “халдварт, төрөх эмэгтэйчүүд, тарианы тасаг, мэс заслын тасаг”-ийн ажилчдын 30% нь В,С вирусын халдвар авсан ба сүрьеэ, хамуу зэрэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарсан халдварт өртөх, хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах зэрэг эрсдлүүд тохиолдож байна.

Эрүүл мэндийн салбарт гарч буй үйлдвэрлэлийн осол улсын хэмжээнд гарч буй нийт үйлдвэрлэлийн ослын 8,4%-ийг эзлэн жилд дунджаар 30 гаруй хүн өртөж байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын сүүлийн 3 жилийн статистикаас харахад 2013 онд 32, 2014 онд 33, 2015 онд 26 тохиолдол бүртгэгдсэн байна.

Иймээс эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнууд, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэдлэг, ойлголтыг сайжруулах шаардлагатай байна.

Сургалтын зорилго: Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмч мэргэжилтнүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай хууль, стандартуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг олгож чадавхижуулахад оршино.

Сургалтын үргэлжлэх хугацаа: 1 өдөр байна. Хичээлийн нэг цаг нь 40 минут /30 минут сэдвийн талаарх үндсэн ойлголт, 10 минут нь асуулт хариулт/ үргэлжилнэ.

Хамрах хүрээ: 8 аймгийн Эрүүл мэндийн газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, нэгдсэн эмнэлгийн ХАБЭА асуудал хариуцсан мэргэжилтэн, өрхийн эмнэлгийн эмч, сумын эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгийн дарга нар хамрагдана.

№	Аймгийн нэр	Оролцогчдын тоо		
		Аймгийн төвөөс	Сумаас	Нийт
1.	Архангай	12	18	30
2.	Булган	15	15	30
3.	Говь-Алтай	8	17	25
4.	Говь-Сүмбэр	18	2	20
5.	Дархан-Уул	19	1	20
6.	Завхан	7	23	30
7.	Баянхонгор	12	38	50
8.	Орхон	19	1	20
Нийт		140	115	255

Сургалт зохион байгуулах хугацаа:

Баянхонгор, Говь-Алтай аймагт 9 сард, Архангай, Булган, Завхан, Говьсүмбэр аймагт 10 сард, Дархан-Уул, Орхон аймагт 11 сард зохион байгуулна

“Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө

д/д	Сэдэв	Ноогдох цаг		
		Бүгд	Лекц	Семинар Дадлага
1	Хөдөлмөрийн хууль, ХАБЭА тухай хууль, бусад эрх зүйн баримтууд	2	2	1
2	Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн асуудал	1	1	
3	Цахилгааны аюулгүй ажиллагаа	1	1	
4	Химийн бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	0,5	0,5	
5	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	1	1	
6	Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	1	1	
7	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогын шалтгаан бууруулах арга зам, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг судлан бүртгэх дүрэм	0,5	0,5	
8	Эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйлийг ажилтанд төлөвшүүлэх	0,5	0,5	
9	Цацрагын үүсгүүртэй харьцах үеийн аюулгүй ажиллагаа	0,5	0,5	
Бүгд цаг		8	8	1

“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

д/д	Хугацаа	Сэдэв
1	08.30-09:00	Бүртгэл
2	09:00-09:10	Сургалтын нээлт / Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, МХАБЭМХ-ны тэргүүн/
3	09:10-09:40	Хөдөлмөрийн хууль, ХАБЭА тухай хууль, бусад эрх зүйн баримтууд
4	09:40-10:10	Хөдөлмөрийн хууль, ХАБЭА тухай хууль, бусад эрх зүйн баримтууд /Сургагч багш/
5	10:10-10:20	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
6	10:20-11:50	Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн асуудал
	10:50-11:00	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
7	11:00-11:20	Завсарлагааны цай
8	11:20-12:00	Цахилгааны аюулгүй ажиллагаа
	12:00-12:10	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
9		
10	12:10-12:40	Химийн бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа
11	12:40-12:50	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
12	12:50-14:00	Үдийн хоол
13	14:00-14:30	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
14	14:30-14:40	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
15	14:40-15:10	Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
16	15:10-15:20	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
17	15:20-15:50	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогын шалтгаан бууруулах арга зам, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг судлан бүртгэх дүрэм
18	15:50-16:00	Асуулт, хариулт /Сургагч багш, оролцогчид/
19	16:00-16:20	Завсарлагааны цай
20	16.20-16:40	Эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйлийг ажилтанд төлөвшүүлэх нь
21	16:40-17:00	Цацрагын үүсгүүртэй харьцах үеийн аюулгүй ажиллагаа
22	17:00-17:10	Цацрагын үүсгүүртэй харьцах үеийн аюулгүй ажиллагаа
23	17:10-17:20	Хаалтын ажиллагаа
24	17:20-17:30	Нэгдсэн зураг авахуулах үйл ажиллагаа